

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
10 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр: Тайлант сарын байдлаар Тамгын газраас 39 бичиг явж, 66 бичиг ирсэн байна.

Албан бичгийг удирдлагад танилцуулан цохолт хийлгэж холбогдох мэргэжилтэнд бүртгэлээр хүлээлгэн өгч, хариу барагдуулан эргэх холбоотой ажиллалаа.

Хариутай 5 албан бичиг ирснээс хугацаандаа 4 албан бичиг явсан. Хугацаа болоогүй 1 бичиг байна. Хугацаатай албан бичгийн барагдуулалт 100% байна.

Тайлант сард багийн Засаг даргын албан тодорхойлолтыг 340 иргэнд гаргаж үйлчилсэн байна.

Сумын Засаг даргын “А” захирамж-33, “Б” захирамж-2, Тамгын газрын даргын “А” тушаал-2 “Б” тушаал-8 тус тус гарсан.

Байгууллагын архиваас нийт 3 лавлагаа олгож, бүртгэл хөтөлсөн.

Баруун-Урт сумын "Төрийн үйлчилгээний оператор" нь 22 төрлийн лавлагааг 117 иргэнд гарган үйлчилсэн.

ХАӨМС-ын шинэчлэлийг өдөр бүр тогтмол хийж, 70 шинэ иргэний мэдээллийг шивж оруулан, баяжилт хийсэн.

Байгууллагын мэдээллийн цагийг мягмар гараг бүр зохион байгуулж тэмдэглэл хөтлөн, үүрэг даалгаврыг албажуулж ажилласан.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын Засаг даргын “А” захирамж-33, “Б” захирамж-2, Тамгын газрын даргын “А” тушаал-2 “Б” тушаал-8 нийт 45 шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, зөрчлийг арилган ажиллаж байна.

3 дугаар улирлын байдлаар Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж 1200 өргөдөл, гомдол ирснийг хүлээн авч, хариу мэдээлж, эргэх холбоотой ажилласан. Өргөдөл, гомдлын барагдуулалт 97%-тай байна. Өргөдөл, гомдлын улирлын тайланг гарган аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хугацаанд хүргүүлсэн.

“Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олонд эрүүл аж төрөх дадал, зан үйлийг төлөвшүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зонхилон тохиолддог халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт иргэдийн оролцоог сайжруулах зорилготой 2 сарын хугацаатай аян зарлаад байна.

Аймгийн ХШҮ-ний цахим санд хууль тогтоомжийн биелэлтийг тухай бүр тайлагнаж байна.

Нийгмийн хамгааллын чиглэлээр:

Нэг байгууллагад-нэг залуу өрхийг хариуцуулан хөгжлийн үйлчилгээнд хамрагдах байгууллага, өрхийн судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлээ.Үүнд:

4-р багийн иргэн Ө.Хүрэл-Очирын гэр бүлд "Шинэ амт" цехийн бүтээгдэхүүний дээжээс бэлэг барьж мөнгөн тусламж үзүүлэн ажлын байранд зуучлахаар болсон.

Лили зочид буудал 6-р багийн иргэн Дамдинжавын Буянцэцэгийг байнгын ажлын байр буюу үйлчлэгчийн орон тоонд авч ажилуулж байна.

8-р багийн малчин Г.Баянмөнх нь Батмандахын Нэргүйбаатарын гэр бүлд иж бүрэн 4 ханатай гэр олгосон.Мөн аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цөөн малтай өрхийг малжуулах хүрээнд 5.000.000 төгрөгийн төсөлд хамруулсан.



"АЙ ЭМ ЖИ ЭФ уул уурхайн компани нь Г.Амартүвшинг туслах ажилчнаар ажилд авсан. Мөн "Номин" агуулах худалдааны Сүхбаатар аймаг дахь салбарын ажилчид 180000 төгрөгийн хүнсний дэмждэг үзүүлсэн.

9-р багийн ажлын алба нь зорилтот бүлгийн өрх, У.Чулуунбаатарын гэр бүлд хөгжлийн үйлчилгээг үзүүлж, нөхөр У.Чулуунбаатарыг блокны үйлдвэрийн туслах ажилтанаар, эхнэр С.Навчийг бууз баншны туслах ажилтанаар ажилд зуучлан байнгын ажлын байраар хангад байна.

Уг арга хэмжээний үр дүнд зорилтот гэр бүл тогтмол орлоготой болж, өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн.

9-р багийн ажлын алба, аймгийн ГБХЗХГ-ын мэргэжилтэн Магадцэцэгтэй хамтран "БҮТЭЭЛЧ БҮСГҮЙЧҮҮД" дэмжих бүлгийн үйл ажиллагааг танилцуулах нэвтрүүлэг, контент бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын цахим хуудсаар нийтэд хүргэсэн.Мөн Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран залуу гэр бүлүүдэд гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн боловсрол олгох талаар нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, гэрлэлтийн гэрчилгээг ёслол төгөлдөр гардуулсан.

9-р багийн ажлын алба "Оюунлаг хайлааст-2" арга хэмжээг зохион байгуулж 10 хүүхэд, 52 ахмадад номын санд уншигчийн карт нээлгэж, төв номын сангийн үйл ажиллагаатай танилцуулан, 10 хүүхдэд нийт 50000 төгрөгний үнэ бүхий номын тэмдэглэл хөтөлдөг дэвтэр, номын хамт бэлэглэсэн.



7-р багийн ажлын албанаас цэргийн албанаас халагдаж ирсэн 2 иргэнд тус бүр 50000 мянган төгрөгийн “Баялаг нарийн боов” цехийн бүтээгдэхүүний дээжээс хүндэтгэл үзүүлээ.

Ахмадын баярын өдрийг тохиолдуулан “Ахмад үеэсээ суралцъя” өдөрлөгийг зохион байгуулсан.



8-р багийн ажлын албанаас тал булгийн уурхайн ажилчин, ахмадуудад архинд донтолт

болон түүний хор уршгийн талаар мэдээлэл хийсэн. Уг арга хэмжээнд нийт 20 хүн хамрагдсан.

7-р багийн ажлын алба, аймгийн ИТХурлын төлөөлөгч Д.Барцэцэгтэй хамт ахмадын баярыг тохиолдуулан хэвтэрт байгаа 8 ахмадын



гэрээр зочилж, баяр хүргэн гарын бэлэг гардуулан, эрүүл мэндийн үзлэг хийж, санал хүсэлтийг нь сонсож ажиллалаа.

Амгалан дэнж сувилалд 2, 4-р багийн 29 ахмадыг аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчидтэй хамтран амруулсан.



9-р багийн иргэн Т.Шархүүхэн

150000 төгрөгний хувцасны тусламж 1 өрхөд, 1-р сургуулийн Одгэрэл багштай 4в ангийн хамт олон 2 өрхөд нийт 200000 төгрөгний хүнсний болон ахуйн хэрэглээний зүйлсийн тусламж үзүүлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

FIRE Төслөөс санаачилсан Гепатитгүй монгол аяны аяны хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвөөс ирүүлсэн эрүүл мэндийн даатгал төлдөггүй 1111 иргэн рүү утсаар холбогдож элэгний В, С вирусийн шинжилгээнд хамрагдах зарыг хүргэж, хамтран ажилласан.

Соёлын чиглэлээр:

“Түүх соёлын үл хөдлөх дурсгал”-ын үзлэг тооллого хийх ажлын хүрээнд сумын Засаг даргын А/328 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийлээ. Сумын хэмжээнд үл хөдлөх 10 хөшөө дурсгалыг тоолж, улсын бүртгэл мэдээллийн санд орууллаа.



Боловсролын чиглэлээр:

Сургууль, цэцэрлэгүүдийн захирал эрхлэгч нарын 10 дугаар сарын ажлын тайланг үнэлэн, ур чадварын нэмэгдлийг хугацаанд олгож ажиллалаа.

Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь өдрийг тохиолдуулан сумын Засаг даргын Тамгын газраас боловсролын салбарын багш ажилтнуудын дунд волейболын тэмцээнийг 4 дэх жилдээ уламжлал болгон зохион байгууллаа. Тэмцээнд боловсролын салбарын 18 байгууллагын 136 тамирчид оролцон хурд хүч авьяас чадвараа дайчлан өрсөлдөж, 4 дүгээр бүрэн дунд сургууль багийн дүнгээр тэргүүн байр, шилжин явах цомын эзэд боллоо.



Мөн ажил мэргэжлээрээ манлайлан ажилласан багш ажилтнуудыг сумын ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр 22, сумын “Засаг даргын Баярын бичиг”-ээр ээр 30 багш, нийт 52 багш, ажилтнуудыг шагнаж урамшууллаа.

“Угийн бичгээ хөтөлж удмын сангаа хамгаалцгаая” сургалтад тус сумын 40 иргэнийг хамрууллаа. Сургалтаар иргэд угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, угийн бичгийн хөтлөх арга, аргачлал сурсан.

Хүүхэд хамгааллын чиглэлээр:

Тайлант сард хүүхдийн тусламжийн 108 дуудлагаар 2 хүүхдийн дуудлага ирж хяналтад авч ажиллаж байна.

“Нэгдүгээрт хүүхэд” аймгийн хүүхдийн VII чуулганд сумын Засаг дарга 4-н сургуулийн нийгмийн ажилтан сургуулийн өөрөө удирдлагын клубийн төлөөлөл болон сумын 5000 гаруй хүүхдүүд төлөөлөн 35 хүүхэд дээрх чуулганд дуу хоолойгоо хүргэн оролцлоо. Хүүхдүүд тулгамдаж буй асуудлуудаа төр засгаар шийдүүлэх, хүүхдүүдтэй хэрхэн хамтран ажиллах талаар үзэл бодлоо хэлэлцэн шийдвэрлэсэн чуулган боллоо.

Тайлант сард архидан согтуурсан гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй 20 кейс ирж нөхцөл байдлын үнэлгээ хийж, хяналтын шатанд явж байна. 8 кейсийг хааж, НАМС праграммд шивэлт хийсэн.

“Монгол өрх” ТББ хамтран хүчирхийлэлд өртсөн 39 иргэнд сэтгэл зүйн үйлчилгээг өгч ажиллалаа.



Спортын чиглэлээр: Зөв хэвшил-Зөв амьдрал” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд багачуудын бие бялдрыг хөгжүүлэх, спортоор хичээллэх идэвхи санаачлагыг өрнүүлэх зорилгоор хөнгөн атлетик, орс таталт, хөгжөөнт буухиа, гимнастрада, гүйлтийн тэмцээнийг Биеийн тамир спортын газартай хамтран Ерөнхий боловсролын багш, сурагчдын дунд зохион байгуулсан.



Нийтийн биеийн тамирийг хөгжүүлэх, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрийг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 8 дугаар багийн иргэд 2-р сургуулийн спорт зааланд биеийн тамирын цагтай боллоо.



Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд Сүхбаатарт үйлдвэрлэв- 2022” үзэсгэлэн худалдаа төв талбайд 2022 оны 09 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд болж өндөрлөлөө. Баруун-Урт сумаас нийт



41 иргэн, аж ахуй нэгж оролцож 2 өдөрт нийт 16700000 мянган төгрөгний бараа бүтээгдэхүүн борлуулсан байна. Тус арга хэмжээ 10 номинаци дэвшүүлэн шалгаруулж Баялаг өндөг цех, хувиараа сийлбэр эрхлэгч Лхасүрэн, хүнсний ногооны төрлөөр Сарангэрэл, мах махан бүтээгдэхүүнээр Баян тал цех, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Оранже нарийн боовны цех, хувиараа оёдол эрхлэгч Буянтгоо нар шагналт байр эзэлсэн байна.

Сумын Засаг даргын А/320 тоот захирамжын дагуу үйл ажиллагаа явуулж буй аж ахуй



нэгжүүдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж нийт 56 байгууллагаар хяналт тавьж ажиллалаа.

Тамхи

худалдан борлуулах хүсэлтэй 2 аж ахуй нэгжид стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран хууль, журмын дагуу хэмжилт хийн зөвшөөрөл олгон ажиллалаа.



Хоршооны хөгжлийн үнэлгээг хоёр жил тутам үнэлж цаашлаад хоршооны үйл ажиллагаанд дүгнэлт хийж хөгжлийн түвшинд нь тохирсон зөвлөмж бэлтгэх зорилгоор 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хүнс хөдөө аж ахуйн газарт сумынхаа Түмэн цагаан ноос, Өндөр хамар, Алтан цацал хоршооны төлөөлүүдтэй тус сургалтад хамрагдан, мэдээ мэдээлэл авч, цаашид хийх ажлын талаар зөвлөмж, мэдээлэл авлаа.

Аймгийн ХХААГ, ЭМГ, МХГ, БШУГ, СХЗХ, Эрдэнэцагаан сумын ЗДТГ, аймгийн Тогоочдын холбоо хамтран хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын ажилчдад "Эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь" сургалт, "Бүсийн аварга тогооч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд манай сумаас 2 тогооч байр эзэлсэн.



Сумын Засаг даргын захирамжийн дагуу сумын нөөц тэжээл, өвсийг бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.



Малын



үүлдэр, угсаа таваарлаг чанарыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 18 хуц, 3 ухныг нийт 8 өрхөд түрээслүүлэн гэрээ байгуулж ажиллалаа.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шүлхийн вакцинжуулалт хийгдэхтэй холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн сумын Засаг даргын А/332 тоот захирамжийн дагуу малын эмч-10, туслах ажилтан-10, жолооч-10 нийт-30 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч вакцинжуулалтын ажил хийгдэж байна.

Мал эмнэлгийн газраас шүлхийн вакцин-54.0 мт авч, ариутгалын бодис ханкон-10кг, ХХХувцас-20 ш, улавч-20 ш, нүдний шил-20 ААН-ийн эмч нарт хуваарилан өглөө.

Шүлхийн вакцинжуулалтад хамрагдвал зохих өрх-997 үхэр- 40745, тугал-13000, гахай-146 нийт-53745 толгой мал хамрагдахаас, одоогийн байдлаар хамрагдсан өрх-108 үхэр-1839, тугал-456 нийт-2295 толгой мал дархлаажуулалтад хамрагдаад байна.

Мал амьтныг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сумын Засаг даргын А/254 тоот захирамжийн дагуу тэмээ-26, үхэр-1934, хонь-44865, ямаа-23133 нийт- 69958 толгой мал, туулгалтад хонь-10250, ямаа-6300, нохой-30 нийт-16580 толгой малд хийгдсэн.

Бруцеллёз өвчний хээлтүүлэгчийн цусны шинжилгээнд: хуц-297, ухна.-167 нийт-464 толгой малаас цус авч МЭГазрын лабораторит өгч ажилласан.

Мал эмнэлгийн газраас Үхрийн арьс товруутах вакцин-1200 мт, шингэлэгч-1.2 л авч Гүн-Гуу мал эмнэлэгт хүлээлгэн өгсөн.

Эрдэнэцагаан сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт “Үхрийн арьс товруутах” өвчин батлагдсантай холбогдуулан голомт болон сэжигтэй бүсэд нутаглаж байгаа Баруун-Урт сумын малчин өрхийн өвчлөмтгий мал сүргийн судалгааг гаргаж эрүүл мэндийн үзлэгт хамруулан дархлаажуулалтын ажил хийгдэхтэй холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн сумын Засаг даргын А/325 тоот захирамж гарган үхэр-882, тугал-306 нийт-1188 Гүн-Гуу мал эмнэлгийн их эмч Г.Нардүүрэн тарьж гүйцэтгэсэн.

Орон нутгийн тарилга, бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын материалыг эмчээс авч нэгтгэл хийсэн.

Хот төлөвлөлт, байгаль орчны чиглэлээр: Сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/310 дугаар тоот захирамжийн дагуу ажлыг хэсэг томилогдож “Яндангаа хөөлье-Өнтэй өвөлжье” аянг шат дараатай зохион байгуулж байна. Баруун-Урт сумын 9 багийн зорилтот бүлгийн 22 айлын судалгааг хэсгийн ахлагч нараар гаргуулан, судалгаанд тулгуурлан, яндан хөөлөх боломжгүй 10 айлыг түүврийн аргаар сонгосон. Зорилтот бүлгийн 9 иргэнийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор байшингийн янданг хөөлж өгч, хөөлөх зааварчилгаа, санамж, мэдээ мэдээллийг өгсөн.

Яндан хөөлөх мэдээ мэдээллийг өгч, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан. Нийт 1000 гаруй иргэнд 2000 гаруй гарын авлага санамжийг түгээсэн.



Байгаль орчин аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн Ш.Нямхүү, мэргэжилтэн Б.Эрдэнэбаяртай хамтран түгээмэл тархацтай ашигт малтмал зөөж тээвэрлэж буй Салхит, Монгол замын ХХК-ны холбогдох албан тушаалтай уулзан менежментийн төлөвлөгөөтэй танилцаж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.



Мөн аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсгийн бие бүрэлдэхүүн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцан, 2021 оны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэсэн.

Сүхбаатар аймгийн малчдын зөвлөгөөн 2022 арга хэмжээг АДАП төслөөс зохион байгуулсан бөгөөд 13 сумын Засаг дарга, холбогдох албаны мэргэжилтэн малчид оролцсон. Уур амьсгалын өөрчлөлт түүнд дасан зохицох, малын тоог толгойг цөөрүүлэх, чанарыг сайжруулах талаар албаны хүмүүс мэдээ мэдээллийг хийн, малчдын саналыг сонсож ажилласан.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн бүх нийтээр мод тарих хөдөлгөөнийг 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Урьдчилсан тоон мэдээгээр төрийн 72 байгууллага, хувийн хэвшлийн 7 байгууллага нийт 19959 ширхэг модыг тариад байна.



Аймгийн төвд хүнд даацын авто машин нийтийн эзэмшлийн зам талбайд түлээний мод зарж байна гэсэн иргэний гомдлын дагуу очиж, газар дээр нь үзлэг шалгалт хийлээ. Гарал үүслийн бичиг болон бусад шаардлагатай баримтууд бүрэн, харин худалдаа үйлчилгээ явуулах зөвшөөрөлгүй худалдаа үйлчилгээ үзүүлсэн нь шалгалтын явцад илэрсэн. Иргэнд холбогдох хууль эрх зүйн мэдээ мэдээллийг өгч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.



Багийн нутаг дэвсгэрт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 6,9-р багийн нутаг дэвсгэрт автобусны зогсоол, 4 тоглоомын талбай, 7 худгийн ойр орчмыг ариутган халдваргүйжүүлэлтийг зохион



байгууллаа.

Батлан хамгаалах бодлого:

Баруун-Урт сумын Засаг даргын захирамжаар 2022 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулж, 18-25 насны 573 залуу хамрагдаж 233 залуу эрүүл мэндийн үзлэгт орж, зөвлөгөө мэдээлэл авсан. Тус сумаас татагдсан залуус аймгийн 338-р анги, Дорнод аймгийн 0132-р анги, 327-р ангид тус тус татагдсан.



МЭДЭЭ НЭГТГЭСЭН
МЭРГЭЖИЛТЭН:

А.ӨЛЗИЙЖАРГАЛ